



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/669

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас “Хариуцлагатай хэрэглээ-хэрэглэгчийн эрх-2019” жил болгон зарласантай холбогдуулан Завхан аймагт болох Баруун бүсийн аймгуудын сургалт, зөвлөгөөнд оролцох орон тооны бус улсын байцаагчдын томилолт, унаа, буудлын зардалд 800.000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд зарцуулах 800.000 төгрөг /найман зуун мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.22 дахь заалтын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах дэд хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганданповрон нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 15-ны өдрийн А/669  
дугаар захирамжийн хавсралт

Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газраас “Хариуцлагатай хэрэглээ-хэрэглэгчийн эрх-2019” жил болгон зарласантай холбогдуулан Завхан аймагт болох Баруун бүсийн аймгуудын сургалтанд 2019 оны 10 дугаар сарын 15-2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрүүдэд оролцох оролцогчдын зардлын тооцоо

д/д	Сургалтанд овог нэр	оролцогсдын	Шатахуун /ирж очих 1300 км/	Томилолт,буудал /3 хоног/
1	Л.Гэрэлмаа			150 000
2	н.Отгонбаяр			150 000
3	н.Жамъянсүрэн			150 000
4	Д.Ганхуяг		200 000	150 000
	Нийт			800 000